



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/304

Хэрлэн сум

Сургалт зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг Алсын хараа-2050, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд сургалтыг зохион байгуулахад 691,400 (зургаан зуун ерэн нэгэн мянга, дөрвөн зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын 27 -ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг, хэмжээ	ХАОАТ-ын суутгал
1	Дизель түлш	3700	122 л	451,400
2	Дизель масло	8000	30 л	240,000
	Нийт дүн			691,400